



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 17 одор

Дугаар А/17

Улаанбаатар хот

Г Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, 2.9 дахь заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоол, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080529


А.
117

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 17 өдрийн
А. дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Жозеф Жорж George Joseph	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001699	Зүрх судлал	Эмчлэх	2017.04.17- 2017.04.27 /11 хоног/
2.	Вагнер Ричард Люис Wagner Richard Lewis	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001700	Чих, хамар, хоолой судлал	Эмчлэх	2017.04.17- 2017.04.30 /14 хоног/
3.	Страчан Кобус Strachan Cobus	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	"СОС Медика Монголиа" ХХК-ийн эмнэлэг	ГЭ0001701	Яаралтай тусламж судлал	Эмчлэх	6 сар
4.	Смоляков Сергей Владимирович Smolyakov Sergey	Оросын Холбооны Улс	"Хос вансэмбэрүү" ХХК-ийн эмнэлэг	ГЭ0001702	Мэдрэл судлал	Эмчлэх	6 сар

Н.
119



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 17 өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хаситана Hasitana	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	"Нью Спринг" ХХК-ийн "Дорнод Увидас" эмнэлэг	ГЭ0001703	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	1 жил